



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 4/438

Улаанбаатар хот

Г Томуугийн цартахлын бэлэн байдал,
хариу арга хэмжээний удирдамж
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Олон улсын эрүүл мэндийн дүрэм 2005, Дэлхийн томуугийн стратеги (2018-2030 он)-ийг хэрэгжүүлэх, томуугийн цартахалтай тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг (2018-2020 он)-г хоёрдугаар, Томуугийн цартахлын вируст халдварын тархварзүйн судалгааны хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар (М.Баттүвшин), Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), Эм, үйлдвэрлэл, технологийн газар (Д.Оюунчимэг)-т тус тус даалгасугай.
3. Удирдамж, төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын төсөв, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт тусгаж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Содномжамц)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 141, 362 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081724

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 10 сарын 29. өдрийн
1/438 дугаар тушаалын 1
дүгээр хавсралт

Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж

1. Үндэслэл

Томуугийн A вирус нь генийн хувьсалд орж эсрэгтөрөгчийн цоо шинэ төрхтэй болсноор уг вирусийн эсрэг ямар ч дархлаагүй хүн амын дунд хурдацтайгаар тархан, дэлхийн улс орнуудыг хамарсан цартахлыг үүсгэдэг. Томуугийн цартахал нь урьдчилан таамаглах боломжгүй, дэлхий дахинд эрүүл мэндийн болон эдийн засгийн ноцтой үр дагавар үүсгэдэг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) нь томуугийн цартахлын бэлэн байдлын удирдамжийг анх удаа 1999 онд боловсруулж, 2005, 2009 онуудад шинэчилсэн. 2009 онд томуугийн A(H1N1) вирусийн шалтгаант 21 дүгээр зууны анхны цартахал гарч, дунджаар 1.8 сая хүн халдварт өртөж, 400 мянга гаруй хүн нас барсан. Цартахлын дараа Олон улсын эрүүл мэндийн дүрэм 2005 (ОУЭМД)-ийн хэрэгжилтийг үнэлэх хороо нь дэлхий нийт томуугийн цартахал, түүнчлэн үүнтэй эн зэрэгцэхүйц нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хангалттай бэлтгэгдээгүй байна гэж дүгнэсэн юм. Томуугийн цартахал нь зөвхөн эрүүл мэндийн салбарт төдийгүй улс орны бүхий л нийгмийн давхарга, салбарын хэвийн үйл ажиллагааг доголдуулж, нийгэм эдийн засгийн ихээхэн хохирол учруулдаг тул хохирол багатай даван туулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх цогц үйл ажиллагааг тусгасан төлөвлөгөөтэй байх шаардлагатай юм. Иймээс энэхүү удирдамжийг Дэлхийн эрүүл мэндийн чуулганы 64.10 дугаар шийдвэр, ДЭМБ-ын цартахлын эрсдэлийн менежментийн стратегийн дагуу боловсруулсан.

2. Зорилго

Томуугийн цартахал болон шинэ вируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган хохирол багатай даван туулах арга хэмжээг зохион байгуулах.

3. Зорилт

- 3.1. Томуугийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, томуугийн цартахал болон шинэ вируст халдварт шуурхай илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах.
- 3.2. Цартахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, тасралтгүй хүргэх, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх.
- 3.3. Цартахлын үед хүн амыг цартахлын вакцинаар шуурхай дархлаажуулах, хүн ам, иргэдийн оролцоог дэмжих замаар халдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах, хязгаарлах.
- 3.4. Хүн ам, ард иргэдийг үнэн зөв, бодит мэдээллээр шуурхай хангах.

4. Цартахлын үе шат

Үе шат	Тодорхойлолт
Цартахал хоорондын үе	Томуугийн вирус амьтны популяцид давамгайлан орчилд орсон байна. Хүнд халдварлах нь ховор.
Цартахлын түгшүүр үе	Шинэ вирус хүнээс хүнд дамжин халдварлах чадвартай болно. Томуугийн шинэ вируст хүний халдвар бүртгэгдэж эхэлнэ.
Цартахлын үе	Шинэ вирус хүн амын дунд өргөн тархаж, хүнээс хүнд дамжин халдварлана. Томуугийн шинэ вирус дэлхий дахинд тархаж, хүн амыг олноор өвчлүүлнэ.
Цартахлын дараах үе	Шинэ вируст халдварын тархалт буурч, ердийн түвшинд хүрнэ. Халдвар эсэргүйцэх арга хэмжээний хүрээг хумиж, нөхөн сэргээх арга хэмжээг авч эхэлнэ.

5. Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэх үүрэг

Улсын хэмжээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллага нь халдварыг эрт илрүүлэх, хүн амыг халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, ард иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй, тасралтгүй хүргэнэ.

5.1. Эрүүл мэндийн яам

- 5.1.1. Цартахлын үеийн салбар хоорондын хамтын үйл ажиллагаа, хариу арга хэмжээг уялдуулан зохицуулах эрхзүйн орчныг бүрдүүлж, бусад яам, агентлагууд, олон улсын байгууллагатай хамтран ажиллана.
- 5.1.2. Цартахлын үеийн эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулна.
- 5.1.3. Цартахлын үеийн шуурхай хариу арга хэмжээний багийг томилон, гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба идэвхжлийн горимд шилжин ажиллана.

5.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв

- 5.2.1. Цартахал болон шинэ вируст халдварыг илрүүлэх, томуугийн дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
- 5.2.2. Цартахлыг хохирол багатай даван туулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, жил бүр тодотгол хийн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.2.3. Цартахлын болон шинэ вируст халдварын сэжигтэй, болзошгүй, батлагдсан тохиолдлыг тухай бүр нь ЭМЯ болон ДЭМБ-д мэдээлэх, эмнэлзүй, тархварзүй, вирус судлалын тандалт, эрсдэлийн үнэлгээ хийж, халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
- 5.2.4. Цартахлын болон шинэ вируст халдварын тандалт, голомтын судалгааг хийж, шаардлагатай тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний багийг орон нутагт томилон ажиллуулж, эрүүл мэндийн байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөмж өгнө.

- 5.2.5. Харуулдан тандалт болон тусгайлсан судалгааны дүн, хөрш зэргэлдээ улс орны мэдээ, мэдээллийг харьцуулан судалж, дүгнэлт гаргана.
- 5.2.6. Шаардлагатай удирдамж, зөвлөмжийг тухай бүр нь шинээр боловсруулж, эрүүл мэндийн байгууллагад шуурхай хүргүүлнэ.
- 5.2.7. Шаардлагатай вирусийн эсрэг эм, вакцин, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис, эмнэлгийн хэрэгсэл зэргийн тооцоог гарган, бэлэн байдлыг хангана.
- 5.2.8. Эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилчдад томуугийн тандалт, эмнэлзүй, халдварын сэргийлэлт, хяналт, сэргийлэх арга хэмжээний талаар цогц сургалт зохион байгуулна.
- 5.2.9. Томуугийн вирусийн зарим омог, тухайн жилийн вакцины омгийн эсрэг дархан ийлдэст бага таньцтай дүйгдсэн, дэд хэвшинж тодорхойгүй омгийг ДЭМБ-ын лавлагаа төвд илгээнэ.
- 5.2.10. Цахим болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүн амыг үнэн зөв, бодит мэдээллээр цаг алдалгүй хангаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сурталчилна.

5.3. Эрүүл мэндийн байгууллагууд

- 5.3.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэртээ томуугийн цартахал болон шинэ вируст халдварыг илрүүлэх, тандах, хариу арга хэмжээг зохион байгуулна.
- 5.3.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг (НЭ), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (БОЭТ), хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь иргэдэд эмнэлгийн тусlamж үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүндрэл, эндэгдлээс урьдчилан сэргийлнэ.
- 5.3.3. Аймаг, нийслэлийн өрхийн Эрүүл мэндийн төв, сумын болон сум дундын Эрүүл мэндийн төв нь иргэдэд анхан шатны тусlamж үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүн амыг халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.3.4. Цартахал болон шинэ вируст халдварын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг “Цартахлын үеийн бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар” (Хүснэгт 3)-тай уялдуулан боловсруулж, жил бүр тодотгол хийн, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.
- 5.3.5. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тусlamж, үйлчилгээний тоног, төхөөрөмжийн бэлэн байдлыг хангана.
- 5.3.6. Цартахлын үеийн хариу арга хэмжээг уялдуулан зохицуулах чиглэлээр салбар хоорондын байгууллагууд (онцгой байдал, цэрэг, цагдаа, хүчний байгууллага, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага гэх мэт)-тай хамтран ажиллана.
- 5.3.7. Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан, эмч, эмнэлгийн ажилчид, ард иргэдэд хүргэнэ.
- 5.3.8. Томуугийн цартахлын болон шинэ вируст хүний халдварын сэжигтэй, болзошгүй тохиолдлыг дээд шатны байгууллагад шуурхай мэдээлнэ.
- 5.3.9. Томуугийн цартахлын болон шинэ вируст халдварын талаарх цаг үеийн байдлын мэдээллийг ЭМЯ, ХӨСҮТ-д яаралтай мэдээлж, хамтран ажиллана.

- 5.3.10. Эмч, эмнэлгийн ажилтны утас, гэрийн хаяг, нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч, эмнэлгийн ажилтны бүртгэл, судалгаа, цартахлын үед ажиллах дүрэм, журмыг эрүүл мэндийн байгууллагын ажилчдад танилцуулж, шаардлагатай зөвлөмж, гарын авлагаар хангаж, тогтмол сургалт явуулна.
- 5.3.11. Халдвартын сэргийлэлт хяналтын багийн тандалт, хяналтын үйл ажиллагааг идэвхжүүлэн, эмч, эмнэлгийн ажилтнуудад халдвараас сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж, хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангана.
- 5.3.12. Ор дэлгэх нэмэлт төлөвлөгөөг жил бүр гарган, төсөвт тусгах.
- 5.3.13. Өвчтөнийг эрэмбэлэн ангилах, жирэмсний үзлэг, хяналт, бага насын хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлэх зэрэг нягтралыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6. Томуугийн цартахал болон шинэ вируст халдвартын үеийн хариу арга хэмжээ

6.1. Эрсдэлийн үнэлгээ

Томуугийн цартахал болон шинэ вируст халдвартын эрсдэлийг цартахлын үе шат бүрт үнэлж, хариу арга хэмжээг зохион байгуулна.

6.1.1. Эрсдэлийн үнэлгээний баг

Эрсдэлийн үнэлгээний баг нь ЭМЯ, ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн холбогдох эмч мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Халдвартын цар хүрээ, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, онцлогоос хамаарч бусад салбаруудын төлөөллийг оролцуулж болно. Эрсдэлийн үнэлгээний баг 6 цагийн дотор эрсдэлийг үнэлэн, холбогдох байгууллагад шуурхай танилцуулна.

6.1.2. Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг дараах асуултын дагуу хийнэ.

6.1.2.1. Вирусийн шинж төрх, хоруу чанарыг үнэлэх:

1. Тухайн вирус нь мутацид орж хүнд халдварлах, өвчлөл үүсгэх илүү хоруу чанартай болсон эсэх;
2. Вирусийн рецептор буюу хүний хамар залгиурын болон уушгинь эсэд холбогдох чадвартай байгаа эсэх;
3. Шууд болон шууд бус хавьтлын замаар хүн болон амьтанд халдварласан эсэх;
4. Вирусийн эсрэг оселтамиивир болон занамиивир эмэнд мэдрэг байдал/тэсвэржилт үүссэн эсэх;

6.1.2.2. Хүн амын онцлог, нийгмийн байдлыг үнэлэх:

1. Шинэ вирусийн эсрэг хүн ам дархлаатай эсэх;
2. Өвчний эмгэг жам, хүндрэл тодорхой байгаа эсэх;
3. Одоогийн улирлын томуугийн вакцины найрлагад байгаа омог томуугийн шинэ вирусийн хэвшинжтэй ижил, төстэй эсэх;

6.1.2.3. Өвчний явц болон тархвар судлалыг үнэлэх:

1. Хязгаарлагдмал газар нутагт, эсвэл хэд хэдэн газарт амьтны популяцид илэрсэн эсэх;
2. Амьтны ямар төрөл зүйлд томуугийн шинэ вирус илэрсэн эсэх (гэрийн тэжээвэр, зэрлэг амьтан гэх мэт). Энэ нь хүнд халдварлах эрсдэлтэй эсэх;

3. Хүн амын дунд халдварт бүртгэгдсэн эсэх (хүнээс хүнд, амьтнаас хүнд халдварт тогтвортой дамжин тархаж байгаа эсэх, өвчлөл голомтолсон эсэх, тохиолдлын тоо гэх мэт);
- 6.1.2.4. Эрсдэлийн дэлгэрэнгүй үнэлгээг Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу хийнэ.
- 6.1.2.5. Эрсдэлийн түвшин, идэвхжлийн зэргийг тогтоож, эрсдэлийн түвшинд тохирсон, эрсдэлийн үеийн харилцаа холбооны арга хэмжээг тушаалын нэгдүгээр хавсралтын зургаадугаар бүлгийн дагуу зохион байгуулна.

6.2. Тандалт, судалгаа

Томуугийн харуулдан тандалтын тогтолцоогоор томуугийн цартахлын болон шинэ вируст халдвартыг эрт илрүүлэн, баталгаажуулна. Хүнээс хүнд тогтвортойгоор дамжин тархаж буй томуугийн шинэ вируст халдварт бүртгэгдэж эхэлсэн үед дараах тохиолдлын тодорхойлолтод тохирсон эхний 100 тохиолдолд тархвар судалгааны хуудас (Хавсралт 3)-ны дагуу судалгаа хийж, халдвартын цар хүрээг тогтооно.

6.2.1. Тохиолдлын тодорхойлолт:

6.2.1.1. Сэжигтэй тохиолдол:

Өвчин эхлэхээс 7-10 хоногийн өмнө халдвартай бүс нутгаар зорчсон, тархвар судлалын холбогдолтой, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдол.

6.2.1.2. Болзошгүй тохиолдол:

Сэжигтэй тохиолдлын тодорхойлолт
БА

Бодит хугацааны полимеразын гинжин урвал (бх-ПГУ)-аар цартахлын вирус илэрсэн,

Цартахлын вирус илрүүлэх иммунохроматографийн аргаар эерэг гарсан тохиолдол.

6.2.1.3. Батлагдсан тохиолдол:

Болзошгүй тохиолдлын тодорхойлолт
БА

Эсийн өсгөвөрт вирус өсгөвөрлөгдсөн

Томуугийн цартахлын вирусийн өвөрмөц эсрэгбие 4 дахин нэмэгдсэн тохиолдол.

6.2.1.4. Голомтолсон өвчлөл

Нэг хамтлаг, хамт олны дунд шалтгаан нь тодорхойгүй, 38⁰C болон түүнээс дээш хэмээр гэнэт халуурсан, амьсгалын замын халдвартын шинжтэй 2 ба түүнээс дээш тохиолдол, эсвэл шалтгаан нь тодорхойгүй амьсгалын замын халдвартын улмаас нас барсан, шинж тэмдэг сүүлийн 7-14 хоногийн дотор газарзүйн нэг бүсэд илэрсэн буюу тархвар судлалын хувьд хамааралтай тохиолдлуудыг хэлнэ.

6.2.2. Цартахлын үед дараах зүйлсийг тандан, судална.

- 6.2.2.1. Томуугийн шинэ вирус болон цартахлын вирусийн газарзүйн тархалт;
- 6.2.2.2. Цартахлын үе шатны өөрчлөлт, халдвартын ерөнхий хандлага;
- 6.2.2.3. Цартахлын тархалтын хурд, нөлөөллийн хэмжээ (эмнэлэгт хэвтэлт, нас барагт, эмнэлзүйн хамшинжүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн тогтолцоонд үзүүлэх нөлөөлөл гэх мэт);

6.2.2.4. Вирусийн эсрэгтөрөгчийн өөрчлөлт, вирусийн эсрэг эмэнд мэдрэг байдал.

6.3. Лабораторийн тандалт

Цартахлын үед лабораторийн оношилгоог дараах зорилгоор хийнэ. Үүнд:

- Томуугийн шинэ вируст халдвартыг эрт илрүүлэх, баталгаажуулах;
- Өвчний газарзүйн тархалтыг хянах;
- Цартахлын вирус болон амьсгалын замын бусад халдвартай өвчтөнүүдийг ялган оношлох, эмнэлзүйн удирдамж боловсруулах;
- Томуугийн вирусийн омгийг тодорхойлох, вирусийн эсрэг эмийн мэдрэг чанарыг хянах;
- Томуугийн вакцины омог, орчилд байгаа вирусийн дэд хэвшинжтэй тохирч байгаа эсэхийг үнэлэх, вакцины үр ашгийг судлах;

6.3.1. Сорьц авах, хадгалах, тээвэрлэх

Тохиолдлыг оношилсон эмч вирусийн эсрэг эмийн эмчилгээ эхлэхээс өмнө өвчний эхний 3 хоногт сорьцыг авна. Өвчтөнөөс хамрын арчдас, хамрын угаадас, тууралтын шингэн, тавны арчдас, ийлдэс цуглуулах ба нас барсан тохиолдлоос уушгины эд (гүнээс) буюу гуурсан хоолойн эд, эсийн сорьц авна. Шинжлэгдэхүүн авах эмч, эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцсыг бүрэн өмсөнө.

6.3.1.1. Шинжлэгдэхүүн цуглуулахад шаардагдах зүйлс:

6.3.1.1.1. Халад, маск (амны хаалт), бээлий, 7-8 см урт уян иштэй ариун бамбар, 2-4 мл вирус зөөвөрлөх орчин бүхий бөглөөтэй хуруу шилнүүд, хуруу шил тогтоогуур, шинжлэгдэхүүн зөөвөрлөх зориулалтын сав, шинжлэгдэхүүнийг дагалдах бичиг

6.3.1.2. Шинжлэгдэхүүн авах:

6.3.1.2.1. Хамрын арчдас авах: Өвчтөний нусыг нийлгэх буюу ариутгасан бамбараар хамрын хөндийн арчдасыг насанд хүрэгсдийг хэвтуулж, хүүхдийг асран хамгаалагчид тэврүүлэн суулгана. Зүүн гарын эрхий, долоовор хуруугаар өвчтөний хамрын үзүүрээс чимхэж, баруун гартаа ариун бамбар барьж болгоомжтой зөвлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын дунд самалдаг хөндийн гүнд том хүнд 4-5 см, хүүхдэд 2-3 см оруулангаа бамбараа салст бүрхүүл рүү шахаж эргүүлэн арчдас авч, 2-3 мл буфержсэн ариун физиологийн уусмал буюу вирус тээвэрлэх уусмалтай хуруу шилэнд хийнэ. Мөн энэ байдлаар хамрын нөгөө хөндийгөөс арчдас авч дээрх уусмалд хийнэ.

6.3.1.2.2. Хамрын угаадас авах: Өвчтөнийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад хамрын хөндий тус бүрт зүүг уян гуурсаар орлуулсан тариураар 4-6 мл ариун физиологийн уусмал хийнгүүт буцаан соруулж, ариун хуруу шилэнд хийнэ. Ийм тариургүй үед дээрх уусмалыг хамарт дусаангут өвчтөнийг бөхийлгэн залгиулахгүйгээр ариун петрийн аяга юмуу юулүүрээр дамжуулан хуруу шилэнд тосч авна.

6.3.1.2.3. Тууралтын шингэн авах: Цэврүүт тууралтын үед гарсан тууралтаас цэврүүний шингэнийг 1 мл-ийн хэмжээтэй тариураар соруулан авч тэжээлт орчин бүхий саванд хийнэ.

6.3.1.2.4. Тавны арчдас авах: Шархны тавны хэсгээс бамбараар арчдас авч, вирус тээвэрлэх орчинтой хуруу шилэнд хийнэ.

6.3.1.2.5. Эд, эсийн сорьц авах: Уушгины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй огтолж аваад ариун саванд хийж таглана.

- 6.3.1.2.6. Ийлдэс цуглуулах: Өвчтөний ийлдэст өвөрмөц эсрэг биеийн таньц тодорхойлох зорилгоор өвчтөнөөс 14-21 хоногийн зайтай хос ийлдсийг ердийн аргаар авна.
- 6.3.1.3. Шинжлэгдэхүүнийг хадгалах, зөөвөрлөх
- 6.3.1.3.1. Хамрын арчдас, хамрын угаадас, хоолойн арчдас, тууралтын шингэн, тавны арчдасыг Улаанбаатар хот дотор бол 24 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, хөлдөөхгүйгээр тээвэрлэж, лабораториид хүргэнэ.
- 6.3.1.3.2. Хөдөө орон нутагт өдөрт нь тээвэрлэх боломжгүй үед -70°C-д хадгалж, эсвэл мөсөн элементтэй саванд 48 цагийн хугацаанд хөлдөөхгүйгээр тээвэрлэж лабораториид хүргэнэ.
- 6.3.1.3.3. Эд, эсийн сорьцыг хөлдөөхгүйгээр аль болох хурдан лабораториид хүргэнэ. Боломжгүй бол -70°C-д хадгалж, хөлдүүгээр тээвэрлэнэ.
- 6.3.1.3.4. Ийлдсийг 7 хоногийн дотор лабораториид илгээх боломжтой бол хөлдөөлгүй сэргүүн нөхцөлд хадгалж, тээвэрлэнэ. Боломжгүй бол -20°C д хадгалж байгаад хөлдүүгээр тээвэрлэж, лабораториид хүргэнэ.
- 6.3.1.4. Шинжлэгдэхүүн хүргүүлэх
Сорьцын дагалдах хуудас (Хүснэгт 5)-ыг гаргацтай бөглөж, шинжлэгдэхүүний хамт лабораториид хүргүүлнэ.
- 6.3.2. Сорьцонд шинжилгээ хийх, эргэн мэдээлэх
- 6.3.2.1. Сорьцонд дараах шинжилгээнүүдийг хийнэ.
- 6.3.2.1.1. Томуугийн вирус илрүүлэх шинжилгээ: бодит хугацааны полимеразийн гинжин урвал (бх-ПГУ);
- 6.3.2.1.2. Томуугийн вирус ялгах шинжилгээ: бх-ПГУ-аар эзрэг гарсан сорьцыг эсийн өсгөвөр, тахианы үр хөврөлд халдааж, өсгөвөрлөх;
- 6.3.2.1.3. Вирусийн эсрэгтөрөгчийн хэвшинжийг тодорхойлох шинжилгээ: өсгөврөөс цус наалдуулах, цус наалдуулахыг saatuuлах урвал;
- 6.3.2.1.4. Вирусийн дэд хэвшинж тодорхойлох шинжилгээ: бх-ПГУ;
- 6.3.2.1.5. Вирусийн эмийн бодист тэсвэржилтийг ДЭМБ-ын зөвлөмж болгосон аргаар тодорхойлно;
- 6.3.2.1.6. Ийлдсэнд эсрэг биеийн таньц тодорхойлох шинжилгээ: цус наалдахыг saatuuлах, эсийн өсгөвөрт саармагжуулах аргаар тус тус хийнэ;
- 6.3.2.2. Шинжилгээний дүнг 7 хоног тутамд утсаар болон цахим хэлбэрээр эргэж мэдээлнэ.
- 6.3.2.3. Ялгасан вирусийн төлөөлөл омгийг АНУ-ын Өвчний Хяналт, Сэргийлэлтийн Төв, Япон улсын Халдварт Өвчний Үндэсний Хүрээлэнгийн Томуугийн Лавлагаа төвд илгээнэ.
- 6.3.2.4. Томуугийн цартахлын вирусийг тодорхойлох бх-ПГУ-ын шинжилгээг ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори, Дархан Уул, Орхон, Ховд, Дорнод аймгийн Вирус судлалын лабораториудад, харин вирус өсгөвөрлөх болон вирусийн эсрэгтөрөгчийн хэвшинжийг цус наалдахыг saatuuлах урвалаар тодорхойлох шинжилгээг ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораториид биоаюулгүй ажиллагааны хоёрдугаар зэрэглэлийн орчинд хийнэ.
- 6.3.2.5. бх-ПГУ-ын шинжилгээний дүн 24-48 цагийн дотор гарна. Томуугийн вирус өсгөвөрлөх шинжилгээний хариу 10-21 хоногийн дараа гарна.

6.4. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ

Томуугийн цартахлын тархалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, олон нийт рүү чиглэсэн эмийн бус дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 6.4.1. Иргэдэд чиглэсэн арга хэмжээ: Томуугаас сэргийлэх, гарын ариун цэвэр сахих, ам, хамраа дарж ханиаж, нийтаах, амны хаалт хэрэглэх, өвчилсөн тохиолдолд гэрийн дэглэм сахих зэрэг халдвартараахаас сэргийлэх аргыг сурталчилна.
- 6.4.2. Бүлэг хүн амд чиглэсэн арга хэмжээ: Албан байгууллага, сургууль, цэцэрлэг, хүүхэд асрах төв, нийтийн байр, цэргийн анги, алслагдмал болон эрсдэлт бүлгийн хүн амд зориулсан зөвлөмж боловсруулж түгээнэ. Олон нийтийг хамарсан арга хэмжээг хязгаарлах, сургууль, цэцэрлэг, хүүхдийн болон үйлчилгээний байгууллагад хөл хорио тогтоох зэрэг аргыг зөвлөмж болгоно.
- 6.4.3. Хил гааль, аялал жуулчлалд чиглэсэн арга хэмжээ: Аялагчдад эрүүл мэндийн зөвлөлгөө өгөх, сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, аялал жуулчлалд хориг тавих зэрэг асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 6.4.4. Тохиолдол ба хавьтталд чиглэсэн арга хэмжээ: Цартахлын болон шинэ вируст хүний халдвартын сэжигтэй, болзошгүй, батлагдсан тохиолдол, тэдгээрийн хавьтлыг тусгаарлаж, эмчийн хяналтад авна.
- 6.4.5. Цартахлын вакцин, дархлаажуулалтын үйл ажиллагаа
- 6.4.5.1. Цартахлын вирусийн халдвартын эсрэг вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлнэ.
- 6.4.5.2. Цартахлын вакцинд эхний ээлжинд эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулна (жирэмсэн эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхэд, 65 болон түүнээс дээш настай, архаг хууч өвчтэй хүмүүс, эрүүл мэндийн байгууллагын ажилчид, цэрэг, цагдаа гэх мэт).

6.5. Эрсдэлийн үеийн харилцаа холбоо

- 6.5.1.1. Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг байгуулан, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.
- 6.5.1.2. Эрүүл мэндийн байгууллага тус бүр эрсдэлийн үеийн харилцаа холбоог хариуцсан ажилтанг томилон ажиллуулна. Харилцаа холбооны багт байгууллагын удирдлага, тандалт, лаборатори, эмнэлзүйн мэргэжлийн эмч нарыг ажиллуулна. Салбар хоорондын оролцоог хангах зорилгоор холбогдох байгууллагуутдай зөвшилцөн тэдний төлөөллийг оролцуулж болно.
- 6.5.1.3. Эрсдэлийн үеийн харилцаа холбооны ажилтан нь мэдээллийг хүлээж авмагц журмын дагуу 2 цагийн дотор олон нийтэд мэдээлж, бодит үнэнийг цаг тухай бүрт нь хэлж, олон нийтийг идэвхжүүлж, аюул осолд өртөхөөс сэрэмжлүүлж, өөрийгөө болон бусдыг эрсдэлээс хамгаалах шийдвэр гаргахад тус болох мэдээллээр хангана.

6.6. Эмнэлгийн тусlamж үйлчилгээ, эмчилгээ

- 6.6.1. Цартахлын үед халдварт өртсөн тохиолдол болгоныг эмнэлэгт хэвтүүлэх болон вирусийн эсрэг эмчилгээнд хамруулах шаардлагагүй. Харин амьсгаадах, цээжээр өвдөх, цэргийн ханиалгах, өндөр халуунтай (38°C), уушги, зүрх судасны өвчин болон чихрийн шижин зэрэг архаг суурь өвчтэй хүнийг эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийг тусгай хяналтад авна. Цартахлын болон шинэ вируст халдвартын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед хүснэгт 6-г баримтлан ажиллана (Томуугийн цартахлын вируст халдвартын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед баримтлах бүдүүвч).

6.6.2. Хүчилтөрөгчийн эмчилгээ

Цусан дахь хүчилтөрөгчийн хэмжээг ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 90%-иас дээш байх, зарим тохиолдолд /жирэмсэн эмэгтэйчүүд/ босго үзүүлэлтийг 92-95% хүртэл түүнээс дээш байлгахаар нэмэгдүүлнэ. Хүчилтөрөгчийн хүнд дутагдалтай өвчтөнүүдэд хүчилтөрөгчийг минутад 10 литр хүртэл хурдтай өгнө.

6.6.3. Вирусийн эсрэг эмчилгээ

Вирусийн эсрэг эмийг эмчилгээнд болон урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ. Халдвартын эрт үед буюу 48 цагийн дотор вирусийн эсрэг эмийг заавар (Хүснэгт 1)-ын дагуу хэрэглэж эхэлнэ. Ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүд, уушгинь үрэвсэл, суурь эмгэг өвчтэй, ХДХВ-ын халдвартай хүмүүст нэн тэргүүнд хэрэглэнэ.

6.6.4. Томуугийн шалтгаантай өндөр халууралт нь ургийн мэдрэлийн гажиг үүсгэх эрсдэлтэй тул ацетоаминофен (Acetaminophen) -ыг хэрэглэнэ.

6.6.5. Эмийн үр дүн, дашрамын нөлөөний илрэл, тухайн эмэнд вирус хир мэдрэг байгаа зэргээс хамаарч вирусийн эсрэг эмийн тун болон хэрэглэх хугацааг өөрчилж болно.

6.6.6. Хөхүүл эхчүүд өвчилсөн тохиолдолд хүүхдийг хөхөөр хооллохгүй бөгөөд нэмэлт тэжээл, сүү хэрэглэнэ. Хөхүүл эхчүүдэд вирусийн эсрэг эм хэрэглэж болно.

6.6.7. Нярай хүүхдэд оселтамивир хэрэглэж болно (Хүснэгт 2).

6.6.8. Хоёрдогч нянгийн халдвартын үед нян судлалын шинжилгээний хариуг үндэслэн тохирох антибиотикийг хэрэглэнэ.

6.6.9. 18 хүртэлх насны хүүхдэд аспирин болон аспирин агуулсан бэлдмэл (бисмут субсалцилат – пепто бисмут) нь Рейгийн хамшинж үүсгэх эрсдэлтэй тул ацетоаминофен, үрэвслийн эсрэг стероидын бус бэлдмэлийг хэрэглэнэ.

Хүснэгт 1.

Томуугийн вирусийн эсрэг эмийн хэрэглэх заавар (эмчилгээ, урьдчилан сэргийлэлт)

Вирусийн эсрэг эм	Насны бүлэг			
	1-6	7-9	10-12	13-18
Занамивир	Эмчилгээ			
	Томуугийн А ба В вирус	Заалтгүй	10 мг (2 цацлага) өдөрт 2 удаа	10 мг (2 цацлага) өдөрт 2 удаа
	Хими сэргийлэлт			
	Томуугийн А ба В вирус	1-4 насанд заалтгүй	5-9 насанд 10 мг (2 цацлага) өдөрт 1 удаа	10 мг (2 цацлага) өдөрт 2 удаа
	Хугацаа	Эмчилгээ	5 хоногийн турш	
		Урьдчилан сэргийлэлт	Сүүлийн тохиолдол илэрснээс хойш 10 хоног	
Осeltамивир	Эмчилгээ			
	Томуугийн А ба В вирус	Хүүхдийн биеийн жингээс эмийн тун хамаарна.		75 мг өдөрт 2 удаа
	Томуугийн А ба В вирус	18 түнээс дээш насны хүнд		75 мг өдөрт 2 удаа
	Хими сэргийлэлт			
	Томуугийн А ба В вирус	Хүүхдийн биеийн жингээс эмийн тун хамаарна.		75 мг өдөрт 1 удаа
	Хугацаа	Эмчилгээ	5 хоногийн турш	
		Хими сэргийлэлт	Сүүлийн тохиолдол илэрснээс хойш 10 хоног	

Тайлбар: Тухайн эмийн үйлдвэрлэгчийн зааврын дагуу тун хэмжээ өөрчлөгдж болно.

Хүснэгт 2.

Томуугийн вирусийн эсрэг эмийн хэрэглэх заавар (нэг хүртэлх насны хүүхдийн эмчилгээ)

Нас	Осeltамивир эмийн эмчилгээний тун
<3 сар	12 мг өдөрт 2 удаа
3-5 сар	20 мг өдөрт 2 удаа
6-11 сар	25 мг өдөрт 2 удаа
Хугацаа	5 хоног

6.7. Халдварын сэргийлэлт, хяналт

6.7.1. Цартахал хоорондын болон дараах үед:

- 6.7.1.1. Эмнэлэг бүрт халдварын сэргийлэлт, хяналтын баг ажиллана. Багийн гишүүд эмнэлгийн халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагааг хариуцна.
- 6.7.1.2. Эмнэлгийн ажилтнуудад халдварын сэргийлэлт, хяналтын сургалтыг жил бүр зохион байгуулж, хувийн хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэх дадлыг эзэмшүүлнэ.
- 6.7.1.3. Эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналтын байдалд жилд 2-оос доошгүй удаа дотоод хяналт, үнэлгээ хийж, илэрсэн дутагдлыг тухай бүр шийдвэрлэнэ.

- 6.7.1.4. Эмнэлэг бүр агаарын сөрөг дараалт бүхий тусгаарлах өрөөтэй байна.
- 6.7.1.5. Тусгаарлах өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хамгаалах хувцас, халдвартгүйжүүлэх бодис, хэрэгслийг бэлтгэн бэлэн байдлыг хангана (Хүснэгт 7).
- 6.7.1.6. Эмнэлгийн ажилтныг жил бүр томуугийн вакцинаар дархлаажуулна.
- 6.7.1.7. Халдварт авах эрсдэлт хүчин зүйлд өртөхөөс сэргийлэх, өртөлтийн дараа авах арга хэмжээнд эмнэлгийн ажилтныг сургана.
- 6.7.1.8. Эмнэлгийн ажилтан, өвчтөний дунд томуугийн эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийж, илэрсэн тохиолдлыг яаралтай тусгаарлана.

6.7.2. Цартахлын түгшүүр үед:

- 6.7.2.1. Цартахал хоорондын үеийн арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.7.2.2. Эмч, эмнэлгийн ажилтны хувийн мэдээлэл, цартахлын үед ажиллах дүрэм, журам, ажил үүргийн хуваарийг нэг бүрчлэн гаргаж, ажилтанд танилцуулж, баталгаажуулна.
- 6.7.2.3. Эмнэлгийн эргэлт, хөдөлгөөнийг хязгаарлах талаар дотоод журамд өөрчлөлт оруулна.
- 6.7.2.4. Нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч, эмнэлгийн ажилтны бүртгэл, судалгааг нарийвчлан гаргаж, гэрээ байгуулан сургалтад хамруулна.
- 6.7.2.5. Эм, оношуур, багаж хэрэгсэл, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисыг цартахал хоорондын үетэй харьцуулахад 20 хувиар нэмэгдүүлж, бэлэн байдлыг хангана. Ханганд нийлүүлэх байгууллагатай тасралтгүй хангах гэрээнд тодотгол хийнэ.
- 6.7.2.6. Эрчимт эмчилгээ, сэхээн амьдрзуулах тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангана.
- 6.7.2.7. Шинэ өвчтөн хүлээн авах болон тусгаарлах өрөөний бэлэн байдал, тусгаарлах ор нэмэх болон эмнэлэг дэлгэх бэлтгэлийг хангана.
- 6.7.2.8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх төлөвлөгөөг гаргаж эмч, мэргэжилтнүүдэд танилцуулна.
- 6.7.2.9. Шаардлагатай тохиолдолд жирэмсний үзлэг, хяналт, дархлаажуулалт зэрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээг өөр газарт түр шилжүүлнэ.
- 6.7.2.10. Эмнэлгийн халдвартын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- 6.7.2.11. Халдвараас сэргийлэх дэглэмийн хэрэгжилтэд 7 хоног бүр дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээ хийж, үр дүнг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргана.
- 6.7.2.12. Эмнэлгийн ажилтнуудын халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх, тайлах дадлыг үнэлж, сургалт зохион байгуулна.
- 6.7.2.13. Эмнэлгийн ажилтан тус бүрийн хамгаалах хувцасны хэмжээ, тохироог гарган, хувцас хэрэгслээр хангана.
- 6.7.2.14. Халдвартын сэргийлэлт, хяналтын дэглэмийг чанд мөрдөн ажиллана.

6.7.3. Цартахлын үед:

- 6.7.3.1. Цартахлын түгшүүр үеийн арга хэмжээг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.7.3.2. Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд өдөр бүр амьсгалын замын халдвартын шинж тэмдэг, шалтгаан тодорхойгүй халууралтын тандалт хийнэ.
- 6.7.3.3. Өвчтөнтэй шууд харьцаж буй эмнэлгийн ажилтнууд өөрсдийн биеийн хэмийг өдөрт 2 удаа тогтмол хянаж, хэрэв халуун нэмэгдэх шинж

илэрвэл эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ. Өвчтөнтэй шууд харьцаж буй эмнэлгийн ажилтанд урьдчилан сэргийлэх тунгаар оселтамиивир эмийг уулгана.

- 6.7.3.4. Эмнэлгийн эргэлт, хөдөлгөөнийг хязгаарлана.
- 6.7.3.5. Халдвартын сэжигтэй болон болзошгүй өвчтөнийг яаралтай тусгаарлана. Эмнэлгийн тусгаарлах ор хүрэлцэхгүй тохиолдолд төлөвлөгөөний дагуу эмнэлэг дэлгэнэ.
- 6.7.3.6. Өвчтөнийг эрэмбэлэн ангилж, амбулаторийн үзлэгийн өрөөг эмнэлгийн орох гол хаалгаас зйтай, олон хүний хөлөөс зайдуу байх зэргээр зохицуулалт хийж, товлолын дархлаажуулалтыг өөр хэсэгт шилжүүлнэ. Бага настын хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн үзлэгийг гэрийн үзлэгт бүрэн шилжүүлнэ.
- 6.7.3.7. Эмнэлэг бүр “Дуугүй хөтөч” болон хөтөч сувилагчийг ажиллуулна.
- 6.7.3.8. Эмнэлзүйн хөнгөн болон дунд хэлбэрийн шинж тэмдэг бүхий өвчтөнийг гэрээр эмчлэх, утсаар зөвлөлгөө өгөх, архаг эмгэгтэй өвчтөнүүдийг гэрийн асаргаанд шилжүүлнэ.
- 6.7.3.9. Халдвартын сэжигтэй өвчтөнийг эмнэлэг хооронд шилжүүлэхгүй, гэрт нь болон эмнэлэгт тусгаарлаж, зөвлөлгөө өгнө.
- 6.7.3.10. Эмч, эмнэлгийн ажилтныг нэмэлтээр дайчлан ажиллуулна.
- 6.7.3.11. Эм, оношуур, багаж хэрэгсэл, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисоор тасралтгүй хангана.
- 6.7.3.12. Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тусламж үзүүлэх өрөөг тусгайлан гаргана.
- 6.7.3.13. Халдвартын сэргийлэлт, хяналтын журам, зааврыг чанд мөрдөж, хяналтын баг, өдөр бүр хяналт үнэлгээ хийж, зөрчлийг арилгана.
